

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 16/438

ШУС, НУС

2015

СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН НЭГДЛИЙГ ХАНГАХ ТУХАЙ АСУУДАЛД

М.Зулькафиль*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: мэдээллийн урсгал, “нэмэлтийн зарчим”, мэдээллийн дэг журам, мэдээлэл олж авах эрх, хэвлэл мэдээллийн дөрвөн онол, сэтгүүл зүйн деонтологи

Дэлхий дахинд мэдээллийн үйл явц маш эрчимтэй даяарш- лагдаж буй орчин үед сэтгүүл зүйн онолыг шинжлэх ухааны үүднээс системчлэх, үзэл баримтлалын хувьд тогтвортой, улам боловсронгуй болгох асуудал хурцаар тавигдаж байна. Цаашид сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны онол дэлхийн улс орнуудын хувьд нийтлэг байх шаардлага ч нийгмийн хөгжлийн өнөөгийн онцлогоос урган гарч байгааг сэтгүүл зүй судлаачид хүлээн зөвшөөрдөг боллоо. Энэ нь хамгийн наад зах нь дараах хоёр шалтгаантай холбоотой юм.

Нэгдүгээрт, энэ шаардлага бол нийгмийн амьдралд ОНМХ-ийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм. Учир нь олон нийтийн мэдээллийн үйл явцыг оновчтой болгох нь хүн төрөлхтний глобаль асуудлын нэг болж хувирчээ. ОНМХ-ийг хүлээн авагчдад зориулан ашиглах асуудал буюу mediakratia, эсвэл mediademo- kratia-гийн аль нь чухал вэ гэдэг

тулгамдсан асуудал онцгой чухал болж байна. Өөрөөр хэлбэл ОНМХ ард түмний эрх ашгийг хамгаалж, ардчиллыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх хэрэгсэл байх уу, эсвэл ОНМХ эздийн буюу үүсгэн байгуулагчид, тэдний ард байгаа улс төр, бизнесийн бүлгийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих уу гэдэг нь сонирхол татаж байна. Хэрэв НҮБ-ын баримт бичгүүдэд тунхагласанчлан хүний бүх эрхийн үндэс нь мэдээлэл олж авах, мэдээлэлтэй байх эрх гэдэг нь үнэн юм бол сэтгүүл зүй public service-ийн үзэл санааг хэрэгжүүлэхтэй холбоотой онолын бүлэг асуудал урган гарах нь гарцаагүй гэдэг нь тодорхой юм.

Хоёрдугаарт, сэтгүүл зүйн онолын одоогийн хөгжил нь түүний үндсэн асуудлуудыг дэлхийн орчин үеийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулах, зарим ойлголтыг эргэж харах асуудлыг дэвшүүлэн тавихад хүргэж байна. Энэ асуудлын хүрээнд орос хэл дээр хэвлэгдсэн “Хэвлэл мэдээллийн дөрвөн онол”, “Масс-медиагийн тухай яриа”, “Сэтгүүл зүй ба ардчилал” зэрэг Америкийн эрдэмтдийн бүтээл анхаарал татах нь тодорхой юм. Онолын асуудлыг мэргэжилтнүүд ч, улс төрчид ч үргэлж сонирхож байсныг бид мэднэ.

Гэхдээ бидний “сэтгүүл зүйн ерөнхий онол” гэж нэрлэж болохоор хичээлийн бүтэц бүрэлдэхүүн нь өнөөдөр хүртэл тийм ч тодорхой бус бөгөөд тэр нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны үндсэн концептуаль асуудлууд, олон нийтийн мэдээллийн болон хэвлэлийн эрх чөлөөний мөн чанар, ОНМХ-ийн нийгмийн үүрэг ба зарчим, сэтгүүл зүйн деонтологи, мэдээллийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх асуудал, мэдээллийн орон зай дахь мэдээллийн дэг журам (мэдээлэлтэй байх, олон ургальч үзэл, хүлээцтэй хандах, харилцан яриа өрнүүлэх), нийтлэлийн үр нөлөө, үр ашиг зэрэг асуудлыг авч үздэг юм.

Орчин үеийн сэтгүүл зүй судлалд хоёр гол хандлага ажиглагдаж байгааг судлаачид тэмдэглэсэн байдаг. Нэг дэх нь сэтгүүл зүйн орчин үеийн нөхцөл байдалд өгсөн дүн шинжилгээ, үзэл бодол нь ирээдүй руу чиглэгдээгүй, гол төлөв янз бүрийн магадлан тэмдэглэх шинжтэй тайлбараар хязгаарлагдсан байдаг. Хоёр дахь нь 2000 оноос хойш эхэлсэн үйл явцтай харьцуулахад ирээдүйд хандах хандлага өөдрөг бус, асуудалтай байгаа явдал юм. Хэрэв онолыг ерөнхийд нь авч үзвэл тоймлон ангилах, тайлбарлах, таамаглах гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд тэдний аль нэгэнд илүү их анхаарал хандуулж, зөвхөн үндсэн шинжийг тайлбарлах ажлаар хязгаарлаж болохгүй гэдэг нь ойлгомжтой. Онол бол бодит байдалд дүн шинжилгээ хийж, тал бүрээс нь тайлбарлахаас гадна хэтийн төлөв, хөгжлийн хандлагыг тодорхойлох учиртай. Гол онцлог нь даяаршил, ардчилал, “нээлттэй нийгэм”-ийн төлөвшил болсон орчин үеийн нийгэмд тохирсон ОНМХ-ийн шинэ байгууллага, ОНМХ-ийн үйл ажиллагааны шинэ соёл болох медиа-

хувьсгалын (media-revolution) тухай байнга ярьж, бичдэг болоод удаж байна. Гэхдээ энэ хувьсгал бол “Өрнөдийн” нийтлэг загварт шилжих төдий алхам биш, шинэ нөхцөлд эерэг үр дүнгээ өгч байгаа бүхнийг ашиглан XXI зууны өөрийн гэсэн онцлог бүхий шинэ загварт шилжих явдал гэж ойлгох нь зүйд нийцнэ.

Орчин үеийн Монголын сэтгүүл зүйд 100 гаруй жилийн практик туршлага, 50 гаруй жилийн сэтгүүл зүйн судлал, шүүмжлэлийн хөгжил, төлөвшлийн туршлага аль аль нь бий. Хөгжлийн дал гаруй жилд манай сэтгүүл зүй хэвлэл мэдээллийн коммунист онолын үзэл баримтлалаар, сүүлийн 25 жилд либертари болон нийгмийн хариуцлагын онолын үзэл баримтлалын дагуу хөгжиж байна. Энэ хугацаанд бахархан ярих ололт амжилт ч, харамсан дурсах алдаа дутагдал ч цөөнгүй байлаа. Тэдний зарим нь өнөөдөр ч хүчтэй ажиглагдсан хэвээр байна. 1990 оноос хойш дэлхий дахины сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагыг дагаад чөлөөт сэтгүүл зүйг хөгжүүлэх, чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн үзэл баримтлалыг шинэ нийгмийн тогтолцоо руу дөнгөж хөл тавьсан Монголын хөрсөнд суулгаж өгөхөд багагүй бэрхшээл тулгарч байна. Тийм бэрхшээлийн нэг нь Монголын сэтгүүл зүй онол, практикийн нэгдлийг зохих түвшинд хангаж чадахгүй, өөрийн гэсэн онолын үзэл баримтлалгүй урсгал шинжтэй явж байгаа явдал юм. Энэ нь дараах хэд хэдэн шалтгаантай холбоотой.

Нэгдүгээрт, Монголын сэтгүүл зүйн түүхэнд чөлөөт сэтгүүл зүйг хөгжүүлж байсан туршлага байгаагүй, ОНМХ-ийн ажилтнуудын энэ талаарх мэдлэг дутмаг учраас хуучин сэтгэлгээнээс амархан салж, бас шинэ сэтгүүл зүйн

нийгмийн үүрэг, зарчим, онолын үзэл баримтлалыг богино хугацаанд эзэмшиж чадахгүй байна.

Хоёрдугаарт, коммунист сэтгүүл зүйгээс либертари сэтгүүл зүй рүү харьцангуй богино хугацаанд огцом шилжсэн учраас асар богино хугацаанд маш олон ХМХ бий болж, түүнд тэр хэмжээгээр сэтгүүлч бус хүмүүс орж ирсэн. Тэд ХМХ-ийг зөвхөн өөрсдийн практик туршлага, эсвэл байгалиас заяасан бичих авьяаст тулгуурлан авч явах болсон юм. Энэ бол сэтгүүл зүй тодорхой чиг баримжаагүй, эсвэл бусдыг даган дууриасан, урсгал шинжтэй явахад хүргэсэн бөгөөд ийм хандлага өнөөдөр ч үргэлжилсээр байна.

Гуравдугаарт, ОНМХ-д ажиллаж байгаа хүмүүсийн онолын мэдлэг ихээхэн дутмаг байна. Энэ нь нэг талаар сэтгүүлчдийг давтан бэлтгэх ажил орхигдсон, нөгөө талаар сэтгүүлч бэлтгэдэг хэт олон их, дээд сургууль бий болж, сургалтын нэгдсэн стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөгүй “сэтгүүлч” бэлтгэх болсонтой холбоотой юм. 2004 онд Стандарт хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр батлагдсан “Сэтгүүлч” мэргэжлийн стандартыг эхний хэдэн жилд мөрдөн ажиллах хандлага ажиглагдаж байсан ч өнөөдөр ихэнх сургууль стандартын тухай “мартсан” гэж хэлж болно.

Дөрөвдүгээрт, их дээд сургуульд багшлах боловсон хүчин дутмаг байна. Онол, практикийн мэдлэг сайтай, чадвартай багш сэтгүүлч бэлтгэдэг аль ч сургуульд хуруу дарам цөөн байна. Тиймээс сайн багштай болох асуудал сэтгүүлч бэлтгэх сургуулиудын хамгийн тулгамдсан асуудлын нэг болж хувирчээ. Мөн ихэнх сургуулийн материаллаг бааз тааруу, мэргэжлийн ном сурах бичиг хангалтгүй байна. Дээр нь оюутнуудыг ерөнхий эрдмийн шалгал-

тын оноог харгалзан элсүүлдэг болсон нь авьяас чадвартай, сэтгүүлч болох гэсэн чин хүсэл сонирхолтой хүнийг элсүүлэх боломжийг бүрэн хаажээ.

Тавдугаарт, нөлөө бүхий ихэнх ОНМХ улс төрч, бизнесмен, эрх мэдэлтэн-олигархуудын гарт төвлөрсөн нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн үүргээ гүйцэтгэж, хариуцлагатай, ёс зүйтэй ажиллахын оронд эздийн үзэл бодол, дуу хоолойн индэр болж хувиргахад хүргэсэн байна. Тэдэнд онолын үзэл баримтлал, чиг баримжаагаас илүү эздийн үзэл бодол, бодлого чухал юм. Энэ нь манайд хэт улстөржсөн, хариуцлагагүй үзэл бодлын сэтгүүл зүй цэцэглэн хөгжихөд нөлөөлж байна. Үүнийг өнөөдөр орон нутгийн жижиг сониноос эхлээд МҮОНРТ-ээс хүртэл түвэггүй ажиглаж болно.

Зургаадугаарт, ОНМХ-ийн үйл ажиллагаа бизнес, түүний гол бүтээгдэхүүн болох мэдээлэл таваар болон хувирсан. Тиймээс ОНМХ олон нийтэд үйлчлэх нийгмийн институт гэсэн утгыг алдаж, бүх юмыг мөнгөний нүхээр харах, мөнгөний төлөө юунаас ч буцахгүй хандлага газар авлаа. Энэ нь захиалгат, үзэл бодлын сэтгүүл зүй, далд реклам хөгжихөд хүчтэй нөлөөлж байна. Байдал ийм байхад сэтгүүл зүйн онолын үзэл баримтлал, чиг баримжааны талаар бодох ОНМХ-ийг эрхлэн гаргагч ч, сэтгүүлч ч олдохгүй гэдэг нь тодорхой юм. Ийм шалтгаан дэндүү их байгаа бөгөөд бид энд хамгийн гол гэсэн цөөн хэдийг дурдлаа.

Дэлхий даяар эрчимтэй өрнөж эхэлсэн медиа-хувьсгалтай холбоотой сэтгүүл зүйн ерөнхий онолыг боловсруулахдаа сэтгүүл зүйн шинжлэх ухааны, философийн арга зүйн хүрээнд хуримтлагдсан нөөц боломжийг ашиглах шаардлагатай байдаг. Арга зүйн

ололт амжилт хангалттай бөгөөд түүнийг бүрэн ашиглах нь мэдээж сэтгүүл зүйн сургалт, судалгааны болон мэргэжлийн байгууллагын зорилт мөн. Гэхдээ ОНМХ-ийн зүй тогтол, сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагыг зөв ойлгоход философийн уламжлалд эсрэг тэсрэгийн нэгдэл ба тэмцэл гэж нэрлэгддэг “нэмэлтийн зарчим” онцгой чухал үүрэгтэй юм. Үүний мөн чанар нь харилцан нэмэлт хийж, дутуу зүйлийг гүйцээхэд орших бөгөөд ийм хандлага аливаа үзэгдэл, асуудал, шийдвэрийг зөв ойлгох боломж олгодог¹ онцлогтой юм. Энэ зарчмыг баримтлах замаар судлаачдын дунд байгаа зөрчилтэй, эсрэг тэсрэг байр суурийг ойлгож, шийдвэрлэх арга замыг эрж хайх боломжтой. Тэдний цөөн хэдийг энд арай дэлгэрэнгүй тайлбарлахыг оролдъё.

Нэгдүгээрт: сэтгүүл зүйн онол, практикт харилцан нэмэлт хийх, нэг нь нөгөөгөө гүйцээх тухай асуудал чухал юм. Онолыг зөвхөн практикийн үндсэн шинжүүдийг тодорхойлж, тайлбарласан концептуаль дүн шинжилгээ төдий зүйл бус, юуны өмнө ОНМХ-ийн объектив зорилтуудыг оновчтой биелүүлэхэд чиглэгдсэн эерэг шийдвэрүүдийг санал болгодог бүтээлч шүүмжлэл гэж хүлээн авах шаардлагатай. Практик бол зөвхөн бодит байдлыг тайлбарлахын зэрэгцээ сэтгүүлчийн үйл ажиллагааны өөрийн зохицуулалтад шаардлагатай оновчтой санааг дэвшүүлдэг онолыг боловсруулах туршилтын бааз юм.

Харамсалтай нь одоохондоо онол, практикийн нэгдэл, нэг нь нөгөөгөө

нөхөх, дутууг гүйцээх асуудал туйлын хангалтгүй гэж хэлж болно. Ихэнх тохиолдолд онол өөрийнхөөрөө оршин тогтнож, практик онолын үзэл санааг хангалтгүй хүлээж авдаг. Буруутныг онолчдын дундаас ч, практик ажилтнуудын дундаас ч эрж хайх хэрэгтэй. Практик ажилтнууд сэтгүүл зүйн зорилго, мөн чанарт тэр бүр тохирохгүй туршлага болон удирдагчдын “заавар зөвлөмж”-ид итгэдэг бол онолчдын боловсруулсан зөвлөмж, хийсэн дүгнэлт нь бүтээлч бус юм. Тиймээс “практик шинжтэй онол” хэрэгтэй бөгөөд түүний нэг хэсгийг онолчдоос, нөгөө хэсгийг практик ажилтнуудаас олох хэрэгтэй. Товчоор хэлбэл манай судлаач-онолчид ба практик ажилт-

нуудын хамтын ажиллагаа, харилцан нөлөөлөл хангалтгүй учраас ОНМХ-ийн үйл ажиллагаа ихэнх тохиолдолд шинжлэх ухааны чиг баримжаагүй, урсгал шинжтэй явж байна.

Хоёрдугаарт: хэрэв сэтгүүл зүйн ардчилсан үзэл санааны хувьд ярих юм бол шууд ба төлөөллийн ардчиллын шаардлагыг хэрэгжүүлэхэд түүнийг өргөн хүрээнд оролцуулахын төлөө тэмцлийн үзэл санааг хамгаалах нь хангалтгүй юм. Жинхэнэ ардчиллын зарчим төлөөллийн (партиципари) болон зөвлөлдөх (делибертари) бүрэлдэхүүн хэсгийн харилцан нөлөөлөл, нэг нь нөгөөгөө нөхөхийг шаардах болно. Харин сэтгүүл зүй энэ нэгдлийг түүнд “тохирсон иргэн”-ийг төлөвшүүлэх замаар хүрэх болно. Үүний үр дүнд иргэний нийгмийн цөм болох мэдээ-

«

*Дэлхий даяар эрчимтэй өрнөж
эхэлсэн медиа-хувьсгалтай
холбоотой сэтгүүл зүйн
ерөнхий онолыг
боловсруулахдаа сэтгүүл зүйн
шинжлэх ухааны, философийн
арга зүйн хүрээнд
хуримтлагдсан нөөц
боломжийг ашиглах
шаардлагатай байдаг*

»

лэлтэй, идэвхтэй олон нийт төлөвших бөгөөд энэ нь бас л ардчилал ба энэрэнгүй үзлийн нэгдэл, харилцан үйлдэлд үндэслэгддэг онцлогтой юм.

Гуравдугаарт: ардчилсан сэтгүүл зүйд олон ургальч үзэл хязгаарлагдмал байх нь түгээмэл бөгөөд тэр нь хүлээцтэй хандах (толерантность) явдалтай хослоогүй тохиолдолд бүдүүлэг, оновчтой биш олон ургальч үзэл, байр суурь ба үзэл бодлын харгис тэмцэл болж хувирдаг. Олон ургальч үзэл хүлээцтэй хандах хоёрыг хослох явдал сэтгүүл зүй дэх янз бүрийн хүчнүүдийн харилцан ярианы үндсэн дээр моно олон ургальч үзлээр дамжин хэрэгждэг юм. Түүнчлэн олон ургальч үзлийг харилцан яриатай хослох нь нийгмийн зөвшилцөлд хүрэхэд нөлөөлдөг чухал хүчин зүйл болдог онцлогтой юм. Европын Зөвлөлийн “ХМХ-ийн салбар дахь маргаашийн бодлого” хэмээх тунхаглалд “олон нийтийн харилцааны хүнлэг энэрэнгүй, ардчилсан шинжийн хэмжүүр” нь олон ургальч үзлийг нийгмийн зөвшилцлийн төлөө хөдөлгөөнтэй цуг хэрэгжүүлэхэд оршино² гэсэн санааг агуулсан нь санамсаргүй зүйл биш юм.

Дөрөвдүгээрт: олон ургальч шинжтэй сэтгүүл зүйд нийгмийн зөвшилцөлд хүрэх арга замыг хайх явдал нийгмийн харьцааны тодорхой бус байдал, мөн “хувийн бүлэглэл” болон “бүх хүн төрөлхтөн”-ий (либертаризм ба коммунитаризм) эсрэг тэсрэг байр суурьтай тулгарах нь түгээмэл юм. Үнэн хэрэг дээрээ хүний болон хүн төрөлхтний мөн чанар нь өөрөө энэхүү уг сурвалжууд хоорондоо харилцан уялдаатай байсныг илэрхийлдэг. Тиймээс сэтгүүлчийн байр суурь болон түүнийг хэрэгжүүлэхэд тэнцвэрт байдлыг хадгалах, тэр ч байтугай харилцан ярианы тусламж-

тайгаар нэгж ба нийтлэг зүйлийн нэгдлийг хангахын төлөө хүчин зүтгэх шаардлагатай. Дашрамд хэлэхэд орчин үед глобаль асуудлын тоо, “өмнө зүг” ба “хойд зүг”-ийн хоорондох, “алтан тэрбум” ба “гурав дахь ертөнц”-ийн хоорондох зөрчил эрс нэмэгдэж буй тохиолдолд харилцан зөвшилцлийн асуудал хурцаар тавигдаж, шинэ сэтгэхүй буюу нэг ёсны шинэ глобализмыг шаардаж байна.

Тавдугаарт: олон ургальч нээлттэй нийгэмд нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд янз бүрийн байр сууринаас ханддаг маш олон “хувийн” мэдээллийн хэрэгсэл оршин тогтнох нь жам ёсны зүйл юм. Тэдний дунд заримдаа “мэдээллийн дайн” болж хувирдаг мэдээллийн тэмцэл өрнөдөг нь зүй ёсны хэрэг юм. Тийм нөхцөлд нийгмийн зөвшилцөлд хүлээцтэй хандах онолыг боловсруулсан, нийгмийн яриа шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ч хүрэх боломжгүй юм. Хэрэв “хувийн” болон “нийтийн” зүйлийн харилцан уялдаа холбоо бодитой байлаа гэхэд нийгэмд хувийн хууль ёсны эрх ашгийг хамгаалдаг ХМХ-ээс гадна нийгмийн эрх ашгийг бүхэлд нь хамгаалаахад чиглэгдсэн, олон нийтийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг ОНМХ байх ёстой. Үүнээс үзэхэд “нэмэлтийн зарчим” гэдэг нь нийгэмд хувийн болон төрийн ОНМХ-ээс гадна сэтгүүл зүйн гурав дахь хэв маяг болох нийгмийн бүх хүчнүүдийн хамтын хүчин чармайлтын үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг төр-олон нийтийн ОНМХ байх шаардлагатай гэдгийг сануулдаг юм. Тэгвэл ОНМХ-ийн бүтцэд “тогтоон баригч болон тэнцүүлэгч”-ийн систем үүсэх бөгөөд энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэсний төдийгүй глобаль зөвшилцлийг эрж

хайх боломжоор хангах, зохицуулах болно.

Зургаадугаарт: сэтгүүл зүйн “дөрөв дэх засаглал”-ын тухай ярихдаа нэг хэсэг нь үүнийг егөөдсөн утгаар хүлээж авах, хоёр дахь хэсэг нь ОНМХ-ийн засаглалын боломжийг бүрэн эсэргүүцэх, гурав дахь хэсэг нь сэтгүүл зүй “дөрөв дэх засаглал”-ын үүргийг онцгой тохиолдолд богино хугацаанд гүйцэтгэх боломжтой гэж үздэг нь түгээмэл ажиглагддаг. Үнэн хэрэг дээрээ хэрэв төлөөллийн болон шууд ардчиллын харилцан хамаарлын тухай үзэл санааны үүднээс хандвал төлөөллийн (эхний гурав) ардчиллын дутууг шууд ардчилал (түүнд сэтгүүл зүй хамаарах бөгөөд “дөрөв дэх засаглал” гэж маш зөв нэрлэсэн) нөхдөг бөгөөд “дөрөв дэх” нь эхний гурвын үргэлжлэл биш, харин тэдэнтэй зэрэгцэн орших “засаглал” юм. ОНМХ-ийн “дөрөв дэх засаглал”-ын үзэл баримтлалыг боловсруулахдаа багагүй бэрхшээл тулгардаг нь тодорхой. Ялангуяа “эхний гурав” болон “дөрөв дэх”-ийн хоорондох харилцан нөлөөллийн асуудал байна. Ер нь онолын үүднээс авч үзвэл харилцан хяналт, оновчтой харилцан нөлөөлөл үйлчлэх ёстой. Гэхдээ бодит практикт “эхний гурав” “дөрөв дэх”-ийг үл зөвшөөрөх, өөрсдийн хяналтын доор ажиллахыг, харин “дөрөв дэх” нь тэднээс дээгүүр гарах, илүү их засаглалыг хэрэгжүүлэхийг хичээдэг. Үүнийг шийдэх арга зам нь өндөр түвшинд боловсруулсан онол ба улс төрийн эр зориг юм.

Долоодугаарт: нэмэлтийн зарчмыг хэрэгжүүлэх хамгийн гол нөхцөл боломж бол эрх чөлөө ба хариуцлагын харилцан уялдаа холбоо, харилцан нөлөөлөл юм. Гэхдээ эрх чөлөөний тухай төсөөлөл ихээхэн хязгаарлагдмал, гол төлөв асуудлын зөвхөн хууль

эрх зүйн болон эдийн засгийн талыг авч үздэг. Тэгвэл философичид бүр дээр үеэс эрх чөлөөг нийгэм-түүхэн шаардлагаар үүссэн чөлөөт үйл ажиллагаан дахь ойлголттой холбон тайлбарладаг. Үүнийг практик утгаар нь Европын конвенцийн 10 дугаар заалт болон Үндэсний хууль эрхийн баримт бичгүүд дэх “хориглолт”-од илэрхийлсэн байдаг. Гэхдээ хариуцлагын асуудлыг арай өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай. Учир нь энэ асуудал өнөөдөр хүн төрөлхтнийг аюулгүй, хүнлэг энэрэнгүй, ардчилсан орчинд хөгжүүлэх тухай глобаль асуудалтай салшгүй холбоотой гэдэг нь тодорхой юм.

Н аймдугаарт: хэрэв одоогоос хэдэн жилийн өмнө сэтгүүл зүй зөвхөн тухайн орон, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж, оршин тогтнодог байсан бол өнөөдөр мэдээллийн глобаль орон зайн тухай ярих боломжтой юм. Гэхдээ асуудлын гол нь улс орнуудын “хил дамжсан” агуулгын хувьд олон ургальч үзэл бүхий мэдээллийн асар их урсгалд байгаа биш юм, харин юуны өмнө хүний дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн мэдээлэл олж авах эрхийг хэрэгжүүлэхэд байгаа юм. Өөрөөр хэлбэл хүний зөв боловсон төлөвших, бодит байдлын талаар үнэн зөв төсөөлөл олж авах, нийгмийн харилцааны чиг баримжааг олж, зөв шийдвэр гаргахад туслах, мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц “хэрэгтэй бөгөөд хүртээмжтэй” мэдээллээр хангах асуудал тулгарч байна. Үүнтэй холбоотой өнөөдөр улс орнуудад болон дэлхий дахины хэмжээний “мэдээллийн дэг журам” тогтоох асуудал хурцаар тавигдаж байна³. Тиймээс “мэдээллийн глобаль орон зай” болон “мэдээллийн дэг журам”

гэсэг хоёр ойлголт харилцан уялдаа холбоонд оршиж, нэг нь нөгөөгөө нөхөж байх ёстой юм. Харин орчин үеийн кибер орон зайд үүссэн “замбараагүй байдал” үүний тод илрэл мөн.

Есдүгээрт: хэрэв онол, практик хоёр харилцан нөлөөлөлгүй, нэг нь нөгөөгөө нөхөх боломжгүй нөхцөлд хэчнээн өндөр түвшинд боловсруулсан онол байлаа гэхэд практикийн сайн зохион байгуулалтын арга хэмжээгүйгээр амьдралд хэрэгжихгүй гэдэг нь ойлгомжтой юм. Энэ бол үндэсний хэмжээнд ч, дэлхий дахины хэмжээнд ч мэдээллийн дэг журмыг тогтооход чиглэгдсэн зохион байгуулалтын бүтэц шаардлагатай гэдгийг харуулж байна. “Дэг журам” гэдэг үгийг анх НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхагт хэрэглэсэн байдаг. Дараа нь энэ асуудлыг НҮБ-ын Соёл, боловсрол, шинжлэх ухааны хороо (ЮНЕСКО), Европын Холбооны Аюулгүйн зөвлөлд нэлээд өндөр түвшинд хөндөх болсон. Хүний эрхийн Европын конвенцийг тунхагласны дараа Европын зөвлөлд Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хариуцсан удирдах хороо, Хүний эрхийн Европын шүүх байгуулагдсан юм. Мөн үндэсний зохион байгуулалтын нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг. Гэхдээ маш нарийн зохион байгуулалттай, үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг “дэг журам” алга байна. Харин манай оронд тийм байгууллага хараахан байгуулагдаагүй бөгөөд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, байгуулагдаад удаагүй байгаа Хэвлэлийн ёс зүйн зөвлөл бол мэдээллийн дэг журам, сэтгүүл зүйн онол, практикийн нэгдлийг хангах ажлаас ихээхэн хол байна. Энэ асуудал тэдний үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарагдахгүй ч байж болох юм. Гэхдээ орчин

үеийн мэдээллийн хувьсгал үүнийг тун удахгүй хурцаар шаардах болно.

Энэ бүхнээс үзэхэд орчин үеийн эрчимтэй даяаршлагдаж буй сэтгүүл зүйд онол, практикийн нэгдлийг өндөр түвшинд хангах нь онцгой ач холбогдолтой бөгөөд үүнийг оновчтой шийдвэрлэхэд нэг нь нөгөөгөө нөхөх, дутууг гүйцээх буюу “нэмэлтийн зарчим” онцгой чухал гэдэг нь тодорхой байна.

Ишлэл

¹ Прохоров Е. П. 2004. Демократия и журналистика. М., с. 188.

² Черных А. 2007. Мир современных медиа. М., с. 41.

³ Землянова Л. М. 2005. Проблема свободы выбора в современной глобализирующейся медиакультуре // Вестник МГУ: “Журналистика”. №1, с. 102.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэннис Э., Мэррил Д. 1993. Беседы о масс-медиа. М.

2. Землянова Л. М. 2005. Проблема свободы выбора в современной глобализирующейся медиакультуре // Вестник МГУ: “Журналистика”. №1.

3. Кин Жон. 1993. Средства массовой информации и демократия. М.

4. Прохоров Е. П. 2004. Демократия и журналистика. М.

5. Сибер Ф. С., Шрамм Ч., Петерсон Т. 1998. Четыре теории прессы. М.

6. Черных А. 2007. Мир современных медиа. М.

7. Зилькафиль М. 2011. Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд // Монголын шилдэг нийтлэл. Боть 31. УБ.

8. Зилькафиль М. 2011. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.

9. Зилькафиль М., Чойсамба Ч. 2005. Дэлхийн сэтгүүл зүй. УБ.

Резюме

В статье раскрывается сущность и теоретико-практическое значение “принципа дополнительности”, являющегося основным фактором взаимодополнения и взаимодействия теории и практики журналистики. Автор, анализируя основные

тенденции развития современной журналистики на основе примеров СМИ, показывает необходимость разработки общей теории журналистики в связи с глобализацией информационных процессов во всём мире и по этому поводу предлагает несколько теоретико-практических предложений.